



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Зон олны нам (ЗОН)-ын нэрийг  
Эрх Чөлөөний Эвсэл нам (ЭЧЭН) болгож  
өөрчилсөн, намын дүрмийн өөрчлөлт  
(шинэчилсэн найруулга)-ийг улсын  
бүртгэлд бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Батзориг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Зон олны нам (ЗОН)-ын дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Г.Банзрагчийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Зон олны нам (ЗОН)-ыг төлөөлж тус намын дарга Б.Цацралаас 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын дээд шүүхэд өргөдөл гаргасан.

Уг өргөдөлд "...2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Зон олны намын Их хурал хуралдаж намын нэр, дүрэмд өөрчлөлт оруулсан тул Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын дагуу хүлээн авч бүртгэж өгнө үү" гээд нийт 82 хуудас материал, 1 ширхэг флашийг ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтууд нь Улс төрийн намын тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам"-ын Хавсралт №5А-д заасан бүрдүүлбэрийн шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, журмын 6.6-д зааснаар Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг гаргасны дагуу өргөдлийг хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Зон олны нам (ЗОН)-ын нэрийг Эрх Чөлөөний Эвсэл нам гэж өөрчилснийг болон намын дүрмийн өөрчлөлт (шинэчилсэн найруулга)-ийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг. Намын дүрэмд өөрчлөлт оруулсан шийдвэр гаргах ажиллагааны тухайд:

Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 6 дугаар зүйлийн 6.1-д "Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухайн шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор намын дарга, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч журмын №5, 5А-д заасан бүрдлийг хангаж Улсын дээд шүүхэд хүргүүлнэ" гэж заасны дагуу 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Зон олны намын ээлжит Их хурлыг хуралдуулан 2024 оны

03 сарын дугаар 26-ны өдөр намын дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг намын дарга Б.Цацралаас ирүүлжээ.

Улсын дээд шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Зон олны намыг улсын бүртгэлд бүртгэсэн бөгөөд тус шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор намын даргаар Б.Цацралыг бүртгэсэн бүртгэл хүчин төгөлдөр байна.

Зон олны намын дүрмийн 17.2-т “Намын Их хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ”, 17.2.1-д “Намын дүрэм, мөрийн хөтөлбөр батлах”, 17.2.3-т “... намын нэрийг өөрчлөх” гэж заасан нь тус намын удирдах дээд байгууллага болох Их хурлын бүрэн эрхэд хамаарна. Намын ээлжит Их хурал дүрэмд заасны дагуу дараах журмаар хуралдаж, холбогдох шийдвэрийг гаргажээ.

1. Намын дүрмийн 17.1-д “Намын Их хурал дөрвөн жилд нэг удаа хуралдана. Ээлжит бус Их хурлыг Бага хурлын гишүүдийн гуравны хоёроос дээш бүрэлдэхүүний саналаар зарлан хуралдуулна...” гэж заасны дагуу намын Бага хурлын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн БХ-06/01 дүгээр “Их хурал зарлан хуралдуулах тухай” тогтоолоор Зон олны намын ээлжит Их хурлыг 2023-2024 оны эхний улиралд багтаан зарлан хуралдуулахаар тогтоосон нь дүрмийн дээрх заалттай нийцсэн гэж үзлээ. Учир нь тус намын дүрэмд намын ээлжит Их хурлыг хэн, хэрхэн зарлах талаар тусгайлан зохицуулаагүй байх тул ээлжит бус Их хурлыг зарлах журмын дагуу явагдсаныг хууль бус гэж үзэх үндэслэлгүй юм.

2. Зон олны намын Бага хурлын 2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн “Их хуралд төлөөлөгч оролцуулах тухай” 2024/В9 дүгээр тогтоолоор ээлжит Их хуралд биечлэн болон цахимаар оролцох төлөөлөгчдийн нийт тоог 80 хүн байхаар тогтоосон байна.

Намын Их хурал 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хуралдаж, тооллогын комиссын “Их хурлын ирц хүчинтэйд тооцох тухай” 01 дүгээр тогтоол, “Намын нэр, дүрмийн өөрчлөлтийг батлах санал хураалтын дүнг батлах тухай” 02 дугаар тогтоолуудаар Их хуралд сонгогдсон 80 төлөөлөгчөөс танхимаар 43 төлөөлөгч, цахимаар 15 төлөөлөгч, нийт 58 (72.5%) оролцсон нь хүчинтэй гэж үзэж, оролцсон нийт төлөөлөгчийн 95% (58 төлөөлөгчөөс 55 дэмжсэн)-ийн саналаар намын нэр, дүрмийн өөрчлөлтийг батлахыг дэмжсэн нь (хуралдааны тэмдэглэл, гишүүдийн бүртгэл, фото зураг, флаш дээрх дүрс бичлэг зэрэг баримтаар нотлогдоно) дүрмийн 17 дугаар зүйлийн 17.2.5-д “Намын Их хуралд сонгогдсон нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол Их хурлыг хүчинтэйд тооцно. Төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэр хүчинтэй болно.” гэж заасантай тус тус нийцжээ.

Зон олны намын дүрэмд Их хуралд оролцох төлөөлөгчдийг сонгох журмын талаар тусгайлсан зохицуулалт байхгүйг дурдах нь зүйтэй.

Хоёр. Намын нэр, бэлгэ тэмдгийн өөрчлөлтийн тухайд:

Намын Их хурлын 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зон олны намын нэр, дүрмийн өөрчлөлтийг батлах тухай” 05 дугаар тогтоолын 1 дэх заалтаар Зон олны намын нэрийг Эрх Чөлөөний Эвсэл нам болгон өөрчилсөн нь Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Нам оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд “нам” гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ.”, 6.4-т “Намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг нь төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, сүм хийд, өөр хуулийн этгээд, бусад намын нэр, бэлгэ тэмдэгтэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй.”, 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн

онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 17.2.3-т “Намын нэрийг өөрчлөх, ...” гэж заасантай болон тус намын дүрэмд нийцсэн байх тул бүртгэх нь зүйтэй байна.

Улс төрийн намын тухай хуулийн 6.4-т “Намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг нь ... өөр хуулийн этгээд, бусад намын нэр, бэлгэ тэмдэгтэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй” гэсэн нь намын товчилсон нэрийн хувьд ч мөн тавигдах шаардлага юм. Хуулийн уг зохицуулалтыг логик агуулга болон хэл зүйн дүрмээр тайлбарлавал, намын нэрийн товчлол нь тухайн намыг нэрлэсэн үгийн эхний үсгээр илэрхийлэгдэнэ гэж ойлгох (толгой үсгээр товчлох арга) бөгөөд үүнээс өөрөөр товчилбол тухайн намын нэрээс зөрж бусдыг төөрөгдүүлэх үр дагавар үүсгэнэ.<sup>1</sup>

Иймд Эрх Чөлөөний Эвсэл намын албан ёсны товчилсон нэр нь (ЭЧЭН) байна. Тус намын Их хурлаар намын шинэ нэрийг (ЭН) гэж товчлохоор заасан нь тухайн намын гишүүдэд буюу дотоодод хэрэглэгдэх товчлол гэж үзнэ. Харин гадагш чиглэсэн харилцаанд буюу тухайн намаас бусад этгээдтэй эрх зүйн харилцаанд оролцоход, тухайлбал улс төрийн сонгуульд, “ЭЧЭН” гэсэн албан ёсны нэрийн товчлол хэрэглэгдэнэ.

Өргөдөлд Өдрийн сонины 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн №019 (7385) дугаарт Зон олны нам оноосон нэр өөрчилснийг зарлуулсан зар, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт (Эрх Чөлөөний Эвсэл нам ЭЧЭН гэсэн) зэрэг шаардагдах бусад баримтыг хавсарган ирүүлсэн болно.

Гурав. Намын дүрмийн шинэчилсэн найруулгын тухайд:

Улс төрийн намын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Энэхүү хуульд заасан хугацаанаас өмнө Зон олны намын Их хурлаас өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Улс төрийн намын тухай хуульд заасан шаардлагын дагуу өөрийн намын дүрмийг өөрчлөн ирүүлсэн нь дээрх хуультай зөрчилдөхгүй тул өргөдлийг хүлээн авах үндэслэлтэй.

Зон олны намын дүрмийн 17.2-т “Намын Их хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ”, 17.2.1-д “Намын дүрэм, мөрийн хөтөлбөр батлах” гэж заасан. Иймд намын Их хурлын 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зон олны намын нэр, дүрмийн өөрчлөлтийг батлах тухай” 05 дугаар тогтоолын 2 дахь заалтаар намын дүрмийн өөрчлөлтийг баталсан нь Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 17.2.1-д “намын дүрэм, ...батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасантай нийцжээ.

Эрх Чөлөөний Эвсэл намын шинэчлэн баталсан дүрэм нь нийт 4 бүлэг, 25 зүйлтэй бөгөөд Нэгдүгээр бүлэг. Ерөнхий зүйл; Хоёрдугаар бүлэг. Цахим систем ба гишүүнчлэл; Гуравдугаар бүлэг. Бүтэц, зохион байгуулалт; Дөрөвдүгээр бүлэг. Бусад гэсэн хэсгээс бүрдэж байна. Уг дүрэм нь Улс төрийн намын тухай хуулийн 15

---

<sup>1</sup> Нэг үгээр илэрхийлэгдэх нэртэй бол (жишээлбэл “ХҮН” гэх мэт) монгол хэлний дүрмийн дагуу товчлол хэрэглэгдэхгүй.

дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлагыг хангасан, өөрөөр хэлбэл хууль зөрчсөн гэх үндэслэл алга байна.

Харин намын дүрмийн зарим нэг зохицуулалтыг тодруулах, тухайлбал намын төлөөллийн төв байгууллага болох Сенат, гүйцэтгэх төв байгууллага болох Удирдах зөвлөл, хяналтын байгууллага болох Арбитрын бүрэн эрхийн хугацаа, Их хурлын шийдвэр гаргах журам (тухайлбал хурлын болон хурлаас гарах шийдвэрийн хүчин төгөлдөр байдал гэх мэт), мөн намын бусад байгууллага болох Улс төрийн боловсролын сангийн бүрэн эрхийн хугацаа, хуралдах, шийдвэр гаргах журмыг нарийвчлан зохицуулах шаардлагатайг дурдах нь зүйтэй. Эдгээрийг Улсын төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан хугацаанд Улсын дээд шүүхэд хүргүүлэх боломжтой.

Иймд Эрх Чөлөөний Эвсэл намын дүрмийн шинэчилсэн найруулга (Зон олны намын Их хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан)-ыг бүртгэх нь зүйтэй байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 17 дугаар зүйлийн 17.2.3-т заасныг тус тус баримтлан Зон олны намын нэрийг Эрх Чөлөөний Эвсэл (ЭЧЭН) нам гэж өөрчлөн бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.2.1-д заасныг тус тус үндэслэн Зон олны намын 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Эрх Чөлөөний Эвсэл намын дүрмийн өөрчлөлт (шинэчилсэн найруулга)-ийг бүртгэсүгэй.

3.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ